



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 25 болон 26 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 06-р сарын 21-нээс 07-р сарын 02-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас хоёр долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 10 дахь дугаарыг хүргэж байна.

1

### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **ОУВС-гийн дүрмийн 4-р заалтын дагуу АНУ-д хийсэн үнэлгээний тайланг 2021 оны 7-р сарын 1-нд нийтэллээ.** Тус тайланд дурдсанаар АНУ-д энэ оны эхний хагаст вакцинжуулалт амжилттай үргэлжилж, цар тахлын тархалтын тоо буурсны зэрэгцээ эдийн засгийг дэмжих томоохон төсөв, мөнгөний бодлогын үр нөлөөгөөр **эдийн засаг хурдтай сэргэж, энэ онд 7 хувиар өсөх төлөвтэй** байгааг зарлалаа. Ирэх онд эдийн засгийн идэвхжил үргэлжилж, 5 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бөгөөд үүнээс ч илүү өсөх боломжтойг тэмдэглэжээ.
- **PWC байгууллагаас дэлхийн эдийн засаг энэ онд 5 хувиар өсөх төсөөллийг зарлалаа.** Тус байгууллагын тооцоогоор 2021 оны сүүл эсвэл 2022 оны эхэн гэхэд дэлхийн эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрэхээр байна. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх **Парисын хэлэлцээрийн дагуу** дэлхийн улс орнууд байгальд ээлтэй төслийг санхүүжүүлэхэд ногоон бондын хэмжээг 40 гаруй хувиар нэмэгдүүлэх буюу 1 их наяд ам.долларт хүргэх төлөвтэй байна. Түүнчлэн, Евро бүсийн Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) санд төвлөрүүлэх санхүүжилтийн хэмжээг 2025 он гэхэд 54 хувиар нэмэгдүүлэх тухай мэдээлэв.
- **Их Британид хөл хорио суларч эрэлт өссөнөөр гарцын хэмжээ нэмэгдэн, тус улсын үйлдвэрлэлийн PMI индекс 6-р сард 64.2-г хүрч өсөв.** Мөн үйлчилгээний PMI 61.7-д хүрсэн нь эрүүл мэндийн салбарын эрэлт нэмэгдэж, шинээр бий болох ажлын байрны тоо хурдтай өсч байгаатай холбоотой байна.
- **АНУ-ын хувийн хэрэглээний өсөлт энэ оны 5-р сард 2-р сартай харьцуулахад 5.3 хувиар өссөн байна.** Түүнчлэн, цалингийн орлого 5-р сард өмнөх сараас 0.8 хувиар өсчээ. ХНБ-наас АНУ-ын ДНБ өмнөх улирлын төсөөллөөс 0.5 хувиар сайжирч, энэ онд 7 хувиар өсөх, инфляц өмнөх улирлын төсөөллөөс 1 хувиар нэмэгдэж 3.4 хувьд хүрэх тухай мэдээллээ.
- **ОРЕС+ газрын тосны нэг өдрийн нийлүүлэлтийг 6-р сард 2.1 сая баррельд хүргэж нэмэгдүүлсэн бөгөөд 8-р сараас дахин нэмэгдүүлэх талаар хэлэлцэж байна.** Тус байгууллагын төсөөллөөр 2021 оны сүүлийн саруудад эдийн засгийн сэргэлтээс шалтгаалан эрэлт нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд

хэрэв гарцын хэмжээ энэ хэвээр хадгалагдвал нийлүүлэлт 8-р сард хүлээгдэж буй эрэлтээс өдөрийн 1.5 сая баррелиар дутах, 4-р улиралд өдрийн 2.2 сая баррелиар дутах буюу нийлүүлэлтийн хомсдолд орно гэж үзэж байна.

- **Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагаас зэсийн эрэлтийн төлвөө танилцууллаа.** Дэлхийн зэсийн үйлдвэрлэл 2021 онд өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 7.8 хувиар өсөх төлөвтэй байна. 2020 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан зэсийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ буураад байсан бол 2021 онд хэд хэдэн шинэ уурхайн төслүүд хэрэгжиж, зэсийн олборлолт нэмэгдэхээр байна. Эрэлт талаас, улс орнуудад ногоон эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд сэргээгдэх эрчим хүч, цахилгаан авто машин зэрэг томоохон төслүүд эрчимжиж, зэсийн эрэлт өсөхөөр байна.
- **Ковид-19-ийн мутацлагдсан “Делта” хувилбар** Евро бүсэд тархаж эхэлсэн нь зарим улс орнууд хөл хориогоо чангатгахад хүргэв. Энэ нь цаашлаад бүсийн эдийн засгийн идэвхжилд

сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тус хувилбар нь өмнөх Их Британийн альфа хувилбартай харьцуулахад тархах чадамж 60 хувь өндөр бөгөөд илүү хор хөнөөлтэй байгаа ажээ.

- **Японы жижиглэн худалдаа 5-р сард өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өссөн нь төсөөлөл болох 7.6 хувиас давав.** Гэвч цар тахлын нөлөөгөөр 2020 онд хувийн хэрэглээ огцом буурсан нөлөөг цэвэрлэж харвал жижиглэн худалдаа 0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин ажилгүйдлийн түвшин өмнөх сараас 0.2 хувиар өсч, 3 хувьд хүрээд байна.

#### Эх сурвалж:

1. Fitch Solutions, [Global Copper Mining Outlook](#)
2. Bloomberg, [Gold Drops to 10-Week Low as Dollar Gains on Haven Demand](#)
3. Business Standard, [Japan's retail sales rise for third month, but overall trend still soft](#)
4. IMF, [United States of America Concluding Statement of the 2021 Article IV Mission](#)
5. Reuters, [Ahead of talks, OPEC forecasts point to oil supply deficit in August](#)
6. World Economic Forum, [Chief Economists Outlook](#)
7. Deloitte, [Weekly global economic update July 2021](#)
8. National Bureau of Statistics of China, [Consumer Prices for May 2021](#)

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- **БНХАУ-ын экспортод суурилсан боловсруулах үйлдвэрлэлийн Caixin PMI индекс** энэ оны 5-р сард 52.0 байсан бол **6-р сард хүлээлтээс доогуур 51.3-д хүрэв.** Үүнд эрэлт болон үйлдвэрлэл удааширсан, экспортын шинэ захиалгын хэмжээ 2 сар дараалан буурсан нь голлон нөлөөлжээ.
- **БНХАУ-ын албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс** энэ оны

5-р сард 51.0 байсан бол **6-р сард хүлээлтээс бага буюу 50.9-д хүрэв.** Мөн албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн бус PMI индекс 5-р сард 55.2 байсан бол 6-р сард хүлээлтээс бага 53.5-д хүрэв. Үйлдвэрлэлийн PMI индекс ийнхүү хүлээлтээс бага гарахад түүхий эд материалын үйлдвэрлэл, шинэ экспортын захиалгын хэмжээ буурсан нь голлон нөлөөлжээ. Үйлдвэрлэлийн дэд бүлгийн индекс (sub-index) өмнөх сард 52.7 хүрч өссөн бол 6-р сард 51.9 хүрч өмнөх сараас

буурав. Харин дотоод эрэлт сайжирсан нөлөөгөөр дотоодын захиалгыг хэмждэг индекс өмнөх сард 51.3-аас энэ сард 51.5 хүрч нэмэгджээ. Нийт үйлдвэрлэлийн орц, гарцын бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэ буурсан (input-output price components) нь нийт үйлдвэрлэлийн үнийн өсөлт саарсныг илтгэж байна.

БНХАУ-ын үйлдвэрлэлийн бус PMI индекс хүлээлтээс багаар нэмэгдэхэд Гуангдонг муж дахь Ковид-19-ийн тохиолдлууд огцом нэмэгдэж, агаарын тээвэрлэлт, нийтийн хоолны болон аялал жуулчлалын үйлчилгээний идэвхжил буурч, салбарын PMI индекс 50-аас доош гарсан нь голлон нөлөөлжээ. Харин цахим худалдаа эрчимжсэний зэрэгцээ барилгын салбарын идэвхжил хадгалагдаж салбарын PMI индекс 60-аас дээш гарав. Энэ нь дэд бүтцийн салбар дахь төсвийн хөрөнгө оруулалтын нөлөө эерэг байгааг харуулж байна.

- **БНХАУ-ын үйлдвэрлэлийн үнийн PPI индекс** энэ оны 5-р сард өмнөх оны мөн үеэс 9 хувиар нэмэгдэж сүүлийн 13 сарын хамгийн өндөр түвшинд хүрч өссөн бол 6-р сард уг түвшин өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Өсөлт өмнөх сарын түвшнээс саарах тооцоололд бараа материалын үнэ 3-р сарын түвшинд хүрч тогтворжсон, дотоод эрэлт удааширсан зэрэг нь голлон нөлөөлөв.
  - Бараа материал, түүхий эдийн үнийг дотор нь дэлгэрүүлж харвал 6-р сард ган, зэсийн үнэ 3-р сарын түвшинд хүрч тогтворжив. Харин шатахууны үнэ 6-р сард өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэн байна.
  - Гангийн салбарын хувьд, БНХАУ-ын боомтууд дээрх төмрийн хүдрийн нөөц бага зэрэг буурсан бол ган бүтээгдэхүүний нөөц өмнөх

оны мөн үеэс өсч, 3-р сараас хойшхи хамгийн өндөр түвшинд хүрэв. Түүнчлэн, дэлхийн зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үнэ 6-р сарын эхнээс алгуур нэмэгдэж байгааг Блүүмбергийн шинжээчид онцолж байна.

- **Хэрэглээний үнийн CPI индекс** 5-р сард өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн бол 6-р сард өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өсөх төлөвтэй байна.
  - Хүнсний үнийн хувьд гахайн махны үнэ 6-р сард өмнөх оны мөн үеэс буурч, хүнсний ногооны дефляц нэмэгдсэн бол жимсний инфляц өсөв (хүнсний үнэ зорилтот 2 хувиас доогуур хадгалагдаж байна).
  - Хүнсний-бус бүрэлдэхүүний хувьд, газрын тосны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглээний сагсан дахь тээвэр, харилцаа холбооны бүлгийн үнэ жилийн 5.5 хувиар өсч, хүнсний бус үнэ жилийн 1.6 хувиар нэмэгдэхэд голлон нөлөөлөв.
  - Өмнөх сарын түвшинтэй харьцуулахад боловсролын секторын зарим үйлчилгээний үнэ нэмэгдэв.

#### *Хөрөнгө оруулалт, худалдаа*

- **БНХАУ-ын үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 5 сард 19.4 их наяд юаниар буюу жилийн 15.4 хувиар өсчээ.
  - Эдийн засгийн идэвхжлийг даган хувийн сектор дэх хөрөнгө оруулалт оны эхний 5 сард 11.25 их наяд юаниар буюу жилийн 18.1 хувиар өсөв.
  - Боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 20.4 хувиар өсөв.



- Дэд бүтцийн барилга байгууламжийн хөрөнгө оруулалт
- **БНХАУ-ын дотоодын үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 5 сард 5.43 их наяд юань хүрч жилийн 18.3 хувиар өссөнөөс орон сууцны хөрөнгө оруулалтын тэлэлт үргэлжилж, жилийн 20.7 хувиар өсч, 4.08 их наяд юаньд хүрлээ.
- **Автомашин үйлдвэрлэл, худалдаа буурч эхэллээ.** Автомашин худалдаа 2021 оны эхний 5 сард 10.9 саяд хүрч, жилийн 36.6 хувиар нэмэгдсэн бол автомашин үйлдвэрлэл эхний 5 сард 10.8 саяд хүрч жилийн 38.4 хувиар нэмэгдэв. Хэдийгээр жилийн дүнгээр өсч байгаа ч зөвхөн 5-р сарыг авч үзвэл 2.1 сая автомашин үйлдвэрлэсэн нь өмнөх сараас 7.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар тус тус буурсан үзүүлэлт болжээ. Мөн 5-р сард 2.1 сая автомашин борлуулагдсан нь өмнөх сараас 5.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурсан дүн юм.

#### *Түүхий эдийн импорт, үйлдвэрлэл*

- **БНХАУ-ын** Монголоос импортлосон коксжих нүүрсний хэмжээ **2021 оны эхний 5 сард** 7.5 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 44.4 хувиар өссөн үзүүлэлт байна. Мөн хугацаанд БНХАУ-ын Канадаас импортлосон коксжих нүүрсний хэмжээ 39.0 хувиар өсч 3.14 сая тоннд, ОХУ-аас

импортлосон коксжих нүүрсний хэмжээ 41.2 хувиар өсч, 3.25 сая тоннд хүрсэн бол Австралиас коксжих нүүрс импортлоогүй хэвээр байна.

- **Гангийн идэвхжил 2021 оны 5-р сарын турш** хадгалагдсан нөлөөгөөр БНХАУ-ын түүхий ган үйлдвэрлэл 99.5 сая тоннд хүрч жилийн **6.6 хувиар өссөнөөс** Шандонг мужийн үйлдвэрлэл 8.0 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 14 хувь, Жиангсу мужийн үйлдвэрлэл 10.9 сая тоннд хүрч жилийн 9.1 хувь, Лианонинг мужийн үйлдвэрлэл 7.2 сая тоннд хүрч жилийн 14 хувиар тус тус нэмэгдсэн бол Хэбэй мужийн үйлдвэрлэл 20.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буурав. Харин оны эхний 5 сард түүхий гангийн дотоодын үйлдвэрлэл 473.1 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар нэмэгдлээ.
- **БНХАУ-ын гангийн импорт 2021 оны 5-р сард** жилийн **5.5 хувиар өсч** 1.2 сая тоннд хүрсэн бөгөөд оны эхний 5 сарын байдлаар жилийн 11.7 хувиар өсч, 6.10 сая тоннд хүрчээ.

#### *Эх сурвалж:*

1. *China React: Caixin PMI drop latest sign export lift waning, Bloomberg*
2. *China Insight: A cooler June for factory-gate prices-gauges, Bloomberg*
3. *Coke/Coking coal monthly report, May sxcoal.com, Fenwei Energy*

## МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/07/01	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	9296.3	0.6%	-0.4%	-7.7%	20.7%	54.0%	КОВИД-19-ийн халдварын тархалт зарим орнуудад эрчимжиж байгаа ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж буй нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж байна. BHP Group-ийн зүгээс тавьсан цалин урамшууллын саналыг нийт ажилчдын 92 хувь нь хүлээн авснаар Чилид болж өнгөрсөн ажил хаялт зогссонтой холбоотойгоор зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс бага зэрэг буурахад нөлөөлөв.
<b>Төмрийн хүдэр</b>	214.4	0.0%	0.8%	4.3%	40.2%	117.8%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтэй байгаа тул төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй. Мөн БНХАУ-ын боомтууд дахь нөөц өмнөх долоо хоногийн түвшнээс буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
<b>Алт</b>	1776.8	0.6%	0.3%	-6.3%	-5.9%	0.1%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байна.
<b>Газрын тос (Брент)</b>	75.8	0.4%	0.0%	6.8%	49.1%	76.6%	Дэлхийн эдийн засгийн сэргэлт үргэлжилснээр эрэлт хүлээлтээс ихээр нэмэгдэх төлөв нь газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна.